



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/524

Хэрлэн сум

Удирдах бүрэлдэхүүний сургалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.3.11.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**


1.Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх, Галшар, Дархан сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнд гамшиг осолтой ажиллах, ослын үеийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулсугай.

2.Удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Тус сургалтад шаардагдах 3,294,544 (гурван сая хоёр зуун ерэн дөрвөн мянга таван зуун дөчин дөрвөн)төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх арга хэмжээг сахилга хариуцлага, чанарын өндөр түвшинд зохион байгуулж дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга, (Хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 19 дугаар сарын 17-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн
ахлагч

М.Мөнхбат

Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч,
Хошууч

Гишүүд

Г.Золжавхлан

Ангиллын сургалт, сурталчилгаа
урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан
мэргэжилтэн, Ахмад

Ч.Гантогтох

Эрэн хайх, аврах салбарын захирагч,
Хошууч

Х.Халы

Шуурхай албаны жолооч, Ахлах ахлагч



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 17-ны дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

СУРГАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| д/д | Сумын нэр | Шатахууны зардал | Томилолт | Бусад зардал | Нийт |
|--------------------------------|-----------|---|-------------------------------|---|-----------|
| 1 | Галшар | Чингис хот – Дархан – Чингис хот 280 км-т 50.4 л 127.000 төгрөг | 4 хүн, 3 хоног 768.000 төгрөг | Сурталчилгааны үзүүлэн материал 500.000 Аннос- 250.000 | 1.645.000 |
| 2 | Дархан | Чингис хот – Галшар – Чингис хот 290 км-т 52.2 л 131.544 төгрөг | 4 хүн, 3 хоног 768.000 төгрөг | Сурталчилгааны үзүүлэн материал 500.000 Аннос- 250.000 | 1.649.544 |
| Нийт – 3.294.544 төгрөг | | | | | |